



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 634

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтооолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 76,829,110.60 (далан зургаан сая найман зуун хорин есөн мянга нэг зуун арван төгрөг жаран мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 0127 УБҮ улсын дугаар, JTMHU09J004026660 арлын дугаартай, Тоёота ландкруйзер-200 маркийн тээврийн хэрэгслийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч Завхан аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батмэнд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд (Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал)-д эзэмшүүлэх, засаж сэлбэн ашиглах, үнийг шинэчлэн тогтоож данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2023 оны 576 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
123006508
32-r huraldaan.docx



Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын газрын
дугаар сарын 2023 оны 02 дугаар тогтоолын хавсралт

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ УНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
ТӨРИЙН ёМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСЧ, ЗАВХАН АЙМГИЙН ёМЧИД
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины марк, Зориулалт.	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн (ашиглалтад) орсон отноо	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)
1	Суудлын автомашин Тойото Ланд крузер Ж200	01-27 УБҮ	JTMHU09J004026660	2009/2010	186,000	76,829,110.60 (далан зургаан сая найман зуун хорин есөн мянга нэг зуун арван нэгэн төгрөг жаран мөнгө)
				НИЙТ ДҮН		